

"1991 оны мал тооллогыг зохион явуулах тухай " Засгийн газрын 341 дүгээр тогтоолын заалтаас:(1991 оны 11 дүгээр сарын 15 ны өдөр баталсан)

2. Аймаг, хот, дүүрэг, сум, хороодын мал тооллогын комиссыг тухайн шатны Ардын Хурлын Гүйцэтгэх Захиргааны даргаар ахлуулан байгуулж, тооллогын бэлтгэл хангах, мал тооллогын ажлыг зохион байгуулах , тогтоосон хугацаанд нь явуулах.

3. Тухайн сум, хорооны нутаг дэвсгэрт оршин суудаггүй иргэдийн (гаднын тавиул) малыг малын эзэн болон маллагч малчны хэнийх нь нэр дээр тоолох асуудлыг сум, хорооны АХГ Захиргаа шийдвэрлэж байх.

4. Мал тооллогыг явцад орон нутгийн хууль хяналт, цагдаагын байгууллагатай хамтран хяналт тавьж ажиллахын хамт, малыг тооллогоос нууж дарагдуула, бусдад тарааж өгөх, эсвэл тооллогын бүртгэлээс зөрүүлэх зэргээр улсын мал тооллогыг санаатай будлиантуулсан гэм буруутай хүмүүст тухай бүр нь хуульд заасан зохих арга хэмжээ авч байхыг аймаг, хот, дүүрэг орон нутгийн хотын АДХГЗ-нд даалгажээ.